

**МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**
/2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 06/

2024 оны 06 дүгээр сарын 10

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл ийн хувь
Стратегийн зорилго 1. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог сайжруулна. (Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2.7.4), (Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 2.7.3, 7.2.4), (Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 4.3.9), (Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө 5.2, 7.5)							
Зорилт 1. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна.							
1	"Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан" системд нэмэлт хөгжүүлэлт хийх	Урсгал зардал	Нэмэлт хөгжүүлэлт хийсэн эсэх	1	1	"Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан" системд нийт 895 удаагийн засвар, шинэчлэлийг хийж, хөгжүүлэлтийг сайжруулан нийт визийн зөвшөөрөл, виз олголт, оршин суух зөвшөөрөл, оршин суух зөвшөөрлийн хугацаа сунгалт, оршин суух зөвшөөрлийн хасалт, оршин суух зөвшөөрлийн хэлбэр өөрчлөлт, паспортын мэдээлэл өөрчлөлт, оршин суух зөвшөөрлийн хаягийн өөрчлөлт, оршин суух үнэмлэх дахин авах, гадаадын иргэний бүртгэлтэй холбоотой системээр 89,384 хүсэлтийг хүлээн авсан бөгөөд 2024 оны 12 дугаар сарын 10-наас 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хооронд 36,911 хүсэлтийг хүлээн авсан.	100
2	Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газрын визийн атташе нарт "Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (ISF)" системд	Урсгал зардал	Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	-	1	Гадаадын иргэний виз бүртгэлийн системд тухайн дипломат төлөөлөгчийн газарт олгогдох визийн зөвшөөрлийн жагсаалтыг харах нэмэлт хөгжүүлэлтийг хийж Гадаад харилцааны яамнаас 02 дугаар сарын 03-ны өдөр ирүүлсэн жагсаалтын дагуу 90 албан хаагчдад холбогдох эрхийг нээж өгсөн. Мөн Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газрын визийн атташе нарт	100

	хандах эрх олгох ажлыг зохион байгуулах					зорилсан Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (ISF)-ийн нэмэлт хөгжүүлэлт хийх ГИХГ/20250103004 дугаартай тендер шалгаруулалтыг 04 сарын 24-ны өдөр зарлан шалгарсан байгууллагатай 05 дугаар сарын 21-ны өдөр гэрээг байгуулан хөгжүүлэлтийг хийж байна. Хэрэгжилтийн хувь 100%	
Зорилт 2. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна.							
3	Улсын хилээр нэвтэрч буй гадаадын иргэдийн мэдээллийн санд буй мэдээллийн зөрүүг арилгах чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Урсгал зардал	Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	0	100	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/153 дугаар тушаалаар баталсан Гадаадын иргэдийн хяналт, бүртгэлийн тогтолцоо, үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг судлах, төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, уялдаа холбоог салбарын хэмжээнд сайжруулах болон холбогдох эрх зүйн актыг боловсронгуй болгох дүгнэлт, санал, шийдвэрийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн гишүүнээр байгууллагын дарга Н.Ууганбаяр, нэгжийн дарга Х.Бэхбат, Ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар хяналтын улсын ахлах байцаагч Н.Дуламсүрэн нар ажиллаж байна.	30
4	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 24.4-т “Гадаадын иргэнийг орон байраар хангасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага түүнийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад 48 цагийн дотор бүртгүүлэх бөгөөд бүртгэлийг цахимаар хийж болно” гэж заасныг хэрэгжүүлэх, гадаадын иргэний 48 цагийн бүртгэлийн тогтолцоог сайжруулж, урсгал, төвлөрөлд дүн	Урсгал зардал	Хууль сахиулах чиг үүргийн байгууллагууд болон аялал жуулчлал, зочид буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд ыг холбосон мэдээллийн систем; Big Data ашиглалтын хувь	-	1/90	Цахим визийн evisa.mn системд гадаадын иргэний хаягийн баталгаажуулалтыг авах нэмэлт сайжруулалт хийх CR-25-MFA-01 хүсэлтийн дугаартай 19,719,700 төгрөгийн үнэ бүхий гэрээг гүйцэтгэгч байгууллага Интерактив ХХК-тай байгуулан хөгжүүлэлт хийгдэж 03 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаанд нэвтрүүлэв. isf.mn систем дээр 48 цагийн бүртгэлийн үйл ажиллагааг хялбаршуулахаар нэмэлт нэвтрэлтийн хэсгийн хөгжүүлэлтийг хийж 02 дугаар сарын 18-ны өдөр ажиллагаанд оруулсан. e-mongolia академитай хамтран хэрэгжүүлэх төлөвлөгөөний саналыг хийж 02 дугаар сарын 17-ны өдөр хүргүүлсэн. 04 дугаар сарын 03-ны өдөр Хил хамгаалах ерөнхий газрын Шалган нэвтрүүлэх албаны 25 сургагч багш нарт, 06.06-ны өдөр Зочид буудлын холбооны 38 аж	100

	шинжилгээ хийх Big Data үүсгэх.					ахуйн нэгжийн төлөөлөлд Гадаадын иргэний 48 цагийн бүртгэлийн талаар сургалт орсон. Монголын мэргэжлийн аялал жуулчлалын холбоотой 2 удаагийн уулзалт, Зочид буудлын холбоотой 1 удаагийн уулзалтыг хийж бүртгэлийн үйл ажиллагааг хябаршуулах саналыг авч Гадаадын иргэний виз бүртгэлийн системд нэмэлт хөгжүүлэлтийг хийв. Мөн зочид буудлын системтэй холбох сервисийн хөгжүүлэлтийн ажлыг 6 дугаар сарын 05-аас эхлүүлээд байна. Тайлант хугацаанд 16,635 гадаадын иргэнийг бүртгүүлсэн байна. Хэрэгжилт 95%	
Стратегийн зорилго 2. Төрийн үйлчилгээнд мэдээллийн технологийн дэвшил, инновац нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ. (Шинэ сэргэлтийн бодлого-Төрийн бүтээмжийн сэргэлт 6.1), (Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 5.3.2)							
Зорилт 1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ.							
5	Мэдээллийн аюулгүй байдлын стандарт MNS ISO270001:2023 нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах	Урсгал зардал	Боловсруулсан журмын тоо	-	10	Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 07-ын өдрийн А/168 дугаар тушаалаар “Кибер аюулгүй байдлыг хангах журам”-ыг баталж байгууллагын албан хаагчид erp.e-mongolia.mn системээр танилцуулж дотоод үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Байгууллагын үйл ажиллагааны 6 дугаар сарын төлөвлөгөөнд 3 журмын төсөл боловсруулахаар тусган ажиллаж байна.	70
6	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээлэл алдагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Data Loss Prevention, Azure технологийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх	Урсгал зардал	Программ нэвтрүүлсэн эсэх; Холбогдсон хэрэглэгчийн тоо	-	1/130	Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ЗДТГ-аас зарласан ДГАЗҮСЗДТГ/20250102036 дугаартай 345,000,000 төгрөгийн төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтаар шалгарсан гүйцэтгэгч байгууллагаас Microsoft 365 E5 оффисийн программын нийт 130 ширхэг лицензийг худалдан авч, Microsoft 365-ийн Azure Data Loss Prevention (DLP) буюу байгууллагын мэдрэмтгий өгөгдлийг (sensitive data) хамгаалж, алдаатай эсвэл зөвшөөрөлгүйгээр алдагдах явдлыг хянах, зогсоох зорилготой аюулгүй байдлын функцийг тохируулж Төвийн албан хаагчдын нийт 60	100

						компьютер, орон нутгийн албан хаагчдын 70 компьютерт суулгаад байна.	
7	Төрийн байгууллагууд хооронд өгөгдөл солилцоог автоматжуулсан интерфейс (API) хөгжүүлэх	Урсгал зардал	Байгууллагын тоо; Хөгжүүлэлтийн тоо	-	8/18	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамтай 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр №Ц/ХУР-2025/436 дугаартай “Үндсэн систем(ХУР)-ийг ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ”, № Ц/ХУР-2025/436 - 97 дугаартай “Үндсэн систем(ХУР)-ийг ашиглан үйлчилгээ үзүүлэх нэмэлт гэрээ”, № Ц/ХУР-2025/436 - 102 дугаартай “Үндсэн систем(ХУР)-ийг ашиглан үйлчилгээ үзүүлэх нэмэлт гэрээ”-ээр нийт 5 байгууллагын 22 төрлийн сервисээр мэдээлэл авч, 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр системд холбон тест хийж байна.	90
8	Гадаадын иргэний урсгал, чиглэл, шилжилт хөдөлгөөний бүртгэл хяналтыг нэгтгэн мэдээллийн нэгдсэн сан үүсгэх ажлыг үе шаттай зохион байгуулж, цаашид дүн шинжилгээ хийх нөхцөл, боломжийг бүрдүүлэх	Урсгал зардал	Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	-	100	ХХЕГ-аас 01 дүгээр сарын 17-ны өдөр ирүүлсэн хил нэвтрэлтийн 20,707,761 мөр бичлэг бүхий мэдээллийг Гадаадын иргэний бүртгэл, хяналтын нэгдсэн системд хөрвүүлэн оруулав. Дээрх мэдээллийг оруулсанаар Гадаадын иргэний виз бүртгэлийн нэгдсэн системээс Улсын хилээр нэвтэрч байгаа гадаадын иргэдийн тоон мэдээллийг боомт тус бүрээр харах боломжтой болсон. Цаашид иргэний мэдээллийг мэдээллийн сан дахь гадаад иргэдийн мэдээлэлтэй холбосоноор дүн шинжилгээ хийх боломж бүрдэх юм. Гүйцэтгэл 80%	70
9	Хилийн боомтод виз мэдүүлэх, олгох киоск машиныг үйлчилгээнд нэвтрүүлэх	Урсгал зардал	Байршуулсан киоск машины тоо; Ашиглалтын хувь	-	41/100	Тоног төхөөрөмж худалдан авах ГИХГ/20240102010 дугаартай тендер шалгаруулалтыг зарлан, гүйцэтгэгч байгууллагыг сонгон шалгаруулж 04 сарын 26-ны өдөр 41 киоск машиныг хүлээн авсан. Киоск машин дээр ажиллах программ хангамжийн хөгжүүлэлтийн ГИХГ/20250103004 дугаартай тендер шалгаруулалтыг 04 сарын 24-ны өдөр зарлан шалгарсан байгууллагатай 05 дугаар сарын 21-ны өдөр гэрээ байгуулан хөгжүүлэлтийг гүйцэтгүүлж байна.	70
10	Оршин суух үнэмлэх хэвлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, үйлчилгээг өргөжүүлэх	Урсгал зардал	Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь;	-	100/1	02 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн Монгол Улсад оршин суух зөвшөөрөл авсан иргэнд олгох оршин суух үнэмлэх хэвлэх 1 киоск төхөөрөмжийг Эдийн засгийн яамны нэг цэгийн үйлчилгээний төвд байршуулав. Тайлант хугацаанд 28,793 ширхэг оршин суух үнэмлэхийн хэвлэлтийг хийв. Гадаадын	100

			Хэвлэх төхөөрөмжийн тоо			иргэдийн ДАН танилт нэвтрэлтийг нэмэгдүүлэх үүднээс гадаадын иргэний утасны дугаараар нэг удаагийн нууц код хүргүүлэх нэмэлт хөгжүүлэлтийг Үндэсний дата төв УТҮГ, И-Монгол академитай хамтран хийж 06 дугаар сарын 12-оос үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр хүлээгдэж байна. Гүйцэтгэл 100%	
11	Хиймэл оюун ухаан (AI)-д суурилсан чатбот хөгжүүлэн зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээнд нэвтрүүлэх	Урсгал зардал	Үйлчилгээнд нэвтрүүлсэн эсэх; Хөгжүүлэлтийн тоо	-	1/1	Хиймэл оюун ухаант чатботын систем нэвтрүүлэх тухай 09/06 дугаартай илтгэх хуудсаар байгууллагын даргад танилцуулсан. МАКСНЕТ ХХК-тай гэрээ байгуулахаар төслийг боловсруулан холбогдох нэгжүүдээс санал авч нэгтгэн 04 дүгээр сарын 18-ны өдөр захиргааны хяналтын хуудасны хамт байгууллагын даргад танилцуулсан бөгөөд гэрээ байгуулах ажлыг 07 сар хүртэл хойшлуулах чиглэл өгсөн.	90
Зорилт 4. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт							
12	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах, биелэлтийг тайлагнах	Урсгал зардал	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, биелэлт	-		“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн жилийн эцсийн хэрэгжилт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлаг, Шадар сайдын ажлын албаны удирдлагад хүргүүлсэн чиглэлийн дагуу авсан арга хэмжээний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оны жилийн эцэс, 2025 оны 1 дүгээр сарын хэрэгжилт, Ерөнхий сайдын 2024 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилт, ХЗДХС-ын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгавар, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд тусгагдсан ажлуудын тайлан хүргүүлэн ажиллаа.	90
13	Байгууллагын гүйцэтгэлийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал	Урсгал зардал	Хүргүүлсэн төлөвлөгөөний	-		Сар бүрийн 25-ны дотор буюу нийт 6 дуаа байгууллагын сарын ажлын төлөвлөгөөнд холбогдох саналыг хүргүүлэн биелэлтийг ханган ажилласан.	90

[illegible]

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин	
			Хүрсэн түвшин (биелэлт)	Үнэлгээ
1.	Монгол хэл бичгийн мэдлэг чадвар дээшлүүлэх сургалтад хамрагдах	сертификат авсан эсэх	Монгол бичгийн анхан шатны цахим хичээл I II шатны сургалтад хамрагдаж сертификат авсан, III шатны сургалтад хамрагдаж байна.	70
2.	Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх АЗ сургалтад хамрагдах	сертификат авсан эсэх	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох АЗ сургалтад 05 дугаар сарын 22-оос 24-ний өдрийн хооронд хамрагдан 05 дугаар сарын 29-ний өдөр 2025/2587 дугаартай гэрчилгээг авсан.	100
Үнэлгээ: 85 хувь				

Төлөвлөгөөг үнэлсэн:
ДАРГА
(албан тушаал)


Тэмдэг


.....
(гарын үсэг)

Төсвийн шууд захирагч
Н.УУГАНБАЯР
(огноо)

2025.06.10


Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА
(албан тушаал)


.....
(гарын үсэг)

Нэгжийн дарга
З.ӨНӨРСАЙХАН

(огноо)
2025.06.10

Тайлагнасан:
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА
(албан тушаал)


.....
(гарын үсэг)

Нэгжийн дарга
Э.ГАНЗОРИГ
(огноо)

2025.06.10